



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: САГ-2021/29/СТА-ТЭЗ**

|   |  |
|---|--|
| <p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a><br/>Улаанбаатар хот<br/>2021 он</p> | <p>Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, тэргүүлэх аудитор<br/>Ц.Наранчимэг<br/>Утас:261663<br/>Цахим хаяг: <a href="mailto:naranchimegts@audit.gov.mn">naranchimegts@audit.gov.mn</a></p> <p>Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор: Я.Самбууням:<br/>Утас:260949<br/>Цахим хаяг: <a href="mailto:sambuunyamyia@audit.gov.mn">sambuunyamyia@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Г.Гүнжидмаа<br/>Утас:261885<br/>Цахим хаяг: <a href="mailto:gunjidmaag@audit.gov.mn">gunjidmaag@audit.gov.mn</a></p> <p>Ахлах аудитор: А.Даваадорж<br/>Утас:261628<br/>Цахим хаяг: <a href="mailto:davaadorja@audit.gov.mn">davaadorja@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Н.Баттөгөлдөр<br/>Утас:261740<br/>Цахим хаяг: <a href="mailto:battuguldurn@audit.gov.mn">battuguldurn@audit.gov.mn</a></p> |
|---|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

|   |    |
|---|----|
| 1.Аудитын санал дүгнэлт .....   | 3  |
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....                         | 5  |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....                                  | 5  |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....                               | 6  |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....                    | 7  |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....                                    | 8  |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....                                | 9  |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....                          | 10 |
| 3. Аудитын тайлан.....  | 11 |
| 3.1 Ерөнхий зүйл.....   | 11 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....                              | 11 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал..... | 12 |
| 3.4 Материаллаг байдал .....  | 12 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт .....  | 12 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....                               | 13 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....                          | 14 |
| 3.8 Аудитын гол асуудал .....   | 14 |
| 3.9 Шилэн дансны мэдээлэл.....  | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....   | 14 |
| 3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал.....                 | 14 |
| 4. Аудитын илрүүлэлт .....  | 15 |
| Залруулсан алдаа .....  | 15 |
| Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....                    | 15 |
| Аудитын зөвлөмж .....   | 15 |
| 5. Менежментийн захидал .....   | 16 |
| 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....                                 | 18 |

## Товчилсон үгийн жагсаалт

|          |  |
|----------|--|
| АДБОУС   | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт                  |
| АОУС     | Аудитын Олон Улсын Стандарт                                    |
| УИХ      | Улсын Их Хурал   |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын<br>Стандарт |



**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОР**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА  
ГОМБОЖАВЫН ЗАНДАНШАТАР  
ТАНАА

2021.04.26 № 1307

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Аудитын санал дүгнэлт

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Монгол Улсын Их Хурлын даргын төсвийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



Д.ЗАНДАНБАТ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

| (мянган төгрөгөөр) |   |                        |                        |
|--------------------|---|------------------------|------------------------|
| Код:               | Тайлангийн үзүүлэлт   | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
| 1                  | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН   | 451,599.9              | 1,644,857.1            |
| 33                 | АВЛАГА  | 7,750.7                | 226,909.8              |
| 35                 | БАРАА МАТЕРИАЛ  | 443,849.2              | 1,417,947.3            |
| 2                  | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН   | 6,768,714.4            | 6,962,120.2            |
| 39                 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ  | 6,768,714.4            | 6,962,120.2            |
| 39200              | Биет хөрөнгө  | 6,518,337.1            | 6,707,539.0            |
| 39300              | Биет бус хөрөнгө  | 250,377.2              | 254,581.2              |
| <b>3</b>           | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>7,220,314.3</b>     | <b>8,606,977.3</b>     |
| 4                  | НИЙТ ӨР ТӨЛБӨР  | 4,150.8                | 205,906.4              |
| 41                 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР   | 4,150.8                | 205,906.4              |
| 41300              | Өглөг   | 4,150.8                | 205,906.4              |
| 5                  | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН  | 7,216,163.5            | 8,401,070.8            |
| 51                 | Засгийн газрын хувь оролцоо   | 7,216,163.5            | 8,401,070.8            |
| 51100              | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 3,560,849.8            | 3,560,849.8            |
| 51200              | Хуримтлагдсан үр дүн  | 3,655,313.7            | 4,840,221.1            |
| <b>6</b>           | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>                    | <b>7,220,314.3</b>     | <b>8,606,977.3</b>     |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)                          | 40,956,554.9           | 47,282,471.1           |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 154,894.5              | 132,476.2              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 154,894.5              | 132,476.2              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 40,801,660.4           | 47,149,994.8           |
| II   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН                              | 40,935,686.1           | 46,010,934.8           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 40,935,686.1           | 46,010,934.8           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 39,697,654.1           | 42,772,081.4           |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 9,833,580.0            | 11,432,537.9           |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,188,207.4            | 1,419,086.1            |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 1,161,040.8            | 1,356,777.6            |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 61,850.0               | 99,727.8               |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 2,837,386.3            | 1,692,309.0            |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,084,146.1            | 3,346,567.9            |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 23,531,443.6           | 23,425,075.2           |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 1,238,032.0            | 3,238,853.4            |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 0.0                    | 0.0                    |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)                    | 20,868.8               | 1,271,536.3            |
| V    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН                          | 0.0                    | 86,629.0               |
| VI   | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)          | 20,868.8               | 1,184,907.4            |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                             | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Цөөнхийн хувь оролцоо | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|------|---|--|-----------------------|------------------------|
| 1    | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 7,299,153.6                            | 0.0                   | 7,299,153.6            |
| 2    | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | (103,858.9)                            | 0.0                   | (103,858.9)            |
| 3    | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 7,195,294.7                            | 0.0                   | 7,195,294.7            |
| 4    | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 5    | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 6    | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 7    | Өмчид гарсан өөрчлөлт                           | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 8    | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 9    | Тайлант үеийн үр дүн                            | 20,868.8                               | 0.0                   | 20,868.8               |
| 10   | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 7,216,163.5                            | 0.0                   | 7,216,163.5            |
| 12   | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт      | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 13   | Дахин илэрхийлсэн үлдэгдэл                      | 7,216,163.5                            | 0.0                   | 7,216,163.5            |
| 14   | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 15   | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт                  | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 16   | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз   | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 17   | Өмчид гарсан өөрчлөлт                           | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 18   | Зарласан ногдол ашиг                            | 0.0                                    | 0.0                   | 0.0                    |
| 19   | Тайлант үеийн үр дүн                            | 1,184,907.4                            | 0.0                   | 1,184,907.4            |
| 20   | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл           | 8,401,070.8                            | 0.0                   | 8,401,070.8            |



## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код: | Тайлангийн үзүүлэлт                                      | 2019 оны 12-р сарын 31 | 2020 оны 12-р сарын 31 |
|------|--|------------------------|------------------------|
| I    | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)                   | 40,934,269.2           | 47,482,592.3           |
| 12   | ТАТВАРЫН БУС ОРЛОГО                                      | 96,184.1               | 332,592.5              |
| 120  | Нийтлэг татварын бус орлого                              | 96,184.1               | 332,592.5              |
| 13   | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО                            | 40,838,085.1           | 47,149,999.8           |
| II   | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                        | 39,121,964.5           | 45,417,523.9           |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 39,121,964.5           | 45,417,523.9           |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                          | 37,883,335.5           | 41,981,532.9           |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                        | 9,833,580.0            | 11,424,910.4           |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл           | 1,188,207.4            | 1,420,598.6            |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал                         | 1,221,582.2            | 1,512,458.1            |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал                        | 4,996.5                | 113,326.4              |
| 2107 | Томилолт, зочны зардал                                   | 2,837,386.3            | 1,860,867.8            |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,015,288.4            | 3,996,867.2            |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                          | 21,782,294.8           | 21,652,504.4           |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 1,238,629.0            | 3,435,991.0            |
| III  | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)      | 1,812,304.6            | 2,065,068.4            |
| V    | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)                | 1,812,901.7            | 2,065,068.4            |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 1,812,901.7            | 2,065,068.4            |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр                                      | 1,812,901.7            | 2,065,068.4            |
| VI   | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)    | (1,812,901.7)          | (2,065,068.4)          |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)        | (597.0)                | 0.0                    |
| 101  | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл         | 597.0                  | 0.0                    |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл        | 0.0                    | 0.0                    |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код  | Үзүүлэлт   | Төлөвлөгөө   | Гүйцэтгэл    | Зөрүү       | Хувь  |
|------|--|--------------|--------------|-------------|-------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР<br>ЗЭЭЛИЙН ДҮН                           | 47,256,195.6 | 44,444,519.0 | 2,811,676.6 | 94.1  |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ  | 44,880,195.6 | 42,486,869.6 | 2,393,326.0 | 94.7  |
| 210  | БАРАА, АЖИЛ<br>ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                             | 43,539,860.4 | 41,676,802.1 | 1,863,058.3 | 95.7  |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл<br>урамшил                           | 11,909,340.7 | 11,424,910.4 | 484,430.3   | 95.9  |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн<br>даатгалд төлөх шимтгэл              | 1,607,761.1  | 1,420,598.6  | 187,162.5   | 88.4  |
| 2104 | Хангамж, бараа материалын<br>зардал                            | 1,786,316.9  | 1,558,253.9  | 228,063.0   | 87.2  |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын<br>зардал                           | 200,000.0    | 174,949.6    | 25,050.4    | 87.5  |
| 2107 | Томилолт, зочны зардал   | 2,520,889.9  | 1,860,867.8  | 660,022.1   | 73.8  |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил,<br>үйлчилгээний төлбөр,<br>хураамж | 4,049,050.9  | 3,996,867.2  | 52,183.7    | 98.7  |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад<br>зардал                             | 21,466,500.9 | 21,240,354.6 | 226,146.3   | 98.9  |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ   | 1,340,335.2  | 810,067.5    | 530,267.7   | 60.4  |
| 2131 | Засгийн газрын урсгал<br>шилжүүлэг                             | 43,053.4     | 41,843.7     | 1,209.7     | 97.2  |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг   | 1,297,281.8  | 768,223.8    | 529,058.0   | 59.2  |
| 22   | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ   | 2,376,000.0  | 1,957,649.4  | 418,350.6   | 82.4  |
| III  | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ<br>ЭХ ҮҮСВЭР                              | 47,256,195.6 | 44,444,519.1 | 2,811,676.5 | 94.1  |
| 31   | УЛСЫН ТӨСВӨӨС<br>САНХҮҮЖИХ                                     | 47,156,195.6 | 44,316,926.6 | 2,839,269.0 | 94.0  |
| 35   | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН<br>ҮЙЛ АЖИЛЛАГААНААС                       | 100,000.0    | 127,592.5    | (27,592.5)  | 127.6 |
| 6    | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                               |              |              |             |       |
| 61   | БАЙГУУЛЛАГЫН ТОО   | 2            | 2            | 0.0         | 100.0 |
| 62   | АЖИЛЛАГСДЫН ТОО  | 646          | 646          | 0.0         | 100.0 |
| 65   | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ  | 646          | 646          | 0.0         | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

(мянган төгрөгөөр)

| Код  | Үзүүлэлт  | Гүйцэтгэл |
|------|---|-----------|
| II   | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН                 | 412,154.8 |
| 21   | УРСГАЛ ЗАРДАЛ                                     | 412,154.8 |
| 210  | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ                   | 412,149.8 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 412,149.8 |
| 213  | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ                                  | 5.0       |
| 2133 | Олгосон санхүүжилт, шилжүүлэг                     | 5.0       |
| I    | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 412,154.8 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого                       | 412,154.8 |
| III  | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)          | 0.0       |
| 9    | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | 0.0       |
| 10   | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0.0       |

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Монгол Улсын Их Хурлын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг зохистой удирдаж авлага, өр, төлбөр үүсгэхгүй байх, нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагааны талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор Н.Баттөгөлдөр нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Г.Гүнжидмаа, Аудитын дөрөвдүгээр газрын захирал, тэргүүлэх аудитор Я.Самбууням нар тус тус хэрэгжүүлсэн.

Улсын Их Хурлын даргын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн ТГ-01/74 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Монгол Улсын Их Хурлын алсын хараа: Монгол Улсын Үндсэн хууль, ардчилсан ёс, хүний эрх, нийтлэг үнэт зүйлс, үндэснийхээ эрх ашгийг дээдэлж, тогтвортой хөгжлийг дэмжин, ард түмний засаглах эрхийг хангасан парламентыг төлөвшүүлнэ.

Ард түмний төлөөллийг хангаж, засаглах эрхийг хангасан парламент байх эрхэм зорилгын хүрээнд дараах стратегийн зорилгыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Үүнд:

- Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг төгөлдөржүүлж, түүний чанар, үр нөлөөг дээшлүүлнэ;
- Улсын Их Хурлын хянан шалгах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлж, хуулийн хэрэгжилт, түүний үр нөлөөг үнэлэх байнгын тогтолцоог бүрдүүлж, чадавхжуулна;
- Улсын Их Хурал төлөөллийн чиг үүргээ үр дүнтэй хэрэгжүүлж, үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангаж, парламентад итгэх иргэдийн итгэлийг бэхжүүлнэ;
- Улсын Их Хурлын гадаад харилцааг өргөжүүлж, парламент хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлнэ;
- Улсын Их Хурлын чадавхыг бэхжүүлж, үйл ажиллагааны үр нөлөөг дээшлүүлнэ;
- Парламентын ажлын мэргэшсэн алба-Улсын Их Хурлын Тамгын газрын чадавхыг дээшлүүлж, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгон, олон улсын жишигт хүргэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль;
- Засгийн газрын 2019 оны “Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 472 дугаар тогтоолын 9 дүгээр хавсралт

“Эрүүл мэндийн салбараас бусад төрийн үйлчилгээний байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн сүлжээ”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэлийн үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, түүний хүлээн зөвшөөрөхүйц байдал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Улсын Их Хурлын даргын төсвийн 2020 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлсөн, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 46,097.6 сая төгрөгөөс 2 хувиар буюу 922.0 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Улсын Их Хурлын даргын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,386.7 сая төгрөгөөр буюу 19.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт  | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | /сая төгрөг/   |
|---|----------------|-----------------|----------------|
|   |                |                 | Өөрчлөлт       |
| Б   | 1              | 2               | 3=2-1          |
| Авлага  | 7.8            | 226.9           | 219.1          |
| Бараа материал                                    | 443.8          | 1,418.0         | 974.2          |
| Үндсэн хөрөнгө                                    | 6,768.7        | 6,962.1         | 193.4          |
| <b>Нийт хөрөнгө</b>                               | <b>7,220.3</b> | <b>8,607.0</b>  | <b>1,386.7</b> |
| Өр төлбөр   | 4.1            | 205.9           | 201.8          |
| Засгийн газрын хувь оролцоо                       | 7,216.2        | 8,401.1         | 1,184.9        |
| <b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b> | <b>7,220.3</b> | <b>8,607.0</b>  | <b>1,386.7</b> |

Авлага дансны үлдэгдэл 226.9 сая төгрөг болж 219.1 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн 205.0 сая төгрөгийн авлага үүссэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,418.0 сая төгрөг болж, 974.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь бэлэг дурсгалын зүйл болон бусад хангамжийн материалын худалдан авалттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,962.1 сая төгрөг болж, 193.4 сая төгрөгөөр өссөн нь зөөврийн компьютер болон хөдөлгөөнт төхөөрөмж, таблет тус бүр 80 ширхгийг худалдан авсан, зарим техник хэрэгслийг шинэчилсэн, программ хангамжийн лиценз худалдан авснаас шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 205.9 сая төгрөг болж, 201.8 сая төгрөгөөр өссөн нь хамтран ажиллах гэрээний төлбөр хүлээгдэж байгаатай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 8,401.1 сая төгрөг болж, 1,184.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгийн өсөлт байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 45,744.8 сая төгрөгөөр, үүнээс урсгал төсөвт 43,184.0 сая, хөрөнгө оруулалтын зардалд 2,560.8 сая төгрөгийг зарцуулахаар тооцож, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 47,256.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 47,156.2 сая төгрөгийг улсын төсвөөс, 100.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 44,316.9 сая төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 127.6 сая төгрөг, нийт 44,444.5 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 42,486.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 1,957.6 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 44,444.5 сая төгрөг буюу 94.1 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардлыг 1,863.1 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 530.3 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засгийн газрын нөөц хөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөцөөс 412.2 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, бараа үйлчилгээний бусад зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг 2021 оны 4 дүгээр сарын 10-ны өдрийн 06:00 цагаас 5 дугаар сарын 8-ны өдрийн 06:00 цаг хүртэлх хугацаанд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн.

Энэ нь аудитыг хийж гүйцэтгэх хуулийн хугацаатай давхацсан тул аудитын баг шалгагдагч байгууллагын анхан шатны баримт авах, биет тооллого хийх боломжгүй нөхцөл байдал үүссэн, ажлын тусгай горимоор ажилласан зэргээс шалтгаалан төлөвлөлтийн үе шатанд тодорхойлсон 10 горим, сорилоос 7-г хэрэгжүүлсэн.

### **3.8 Аудитын гол асуудал**

Улсын Их Хурлын 2008 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам"-д заасны дагуу УИХ-ын гишүүдийн төсөвт зардлыг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаж хэвшээгүй, анхан шатны баримтын /е-баримт/ шаардлагыг бүрэн хангаагүй байна.

### **3.9 Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд 130 мэдээлэл байршуулахаас хугацаандаа 111 мэдээлэл, хугацаа хоцроож 19 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5.0 сая төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 50.0 хувьтай байна.

### **3.11 Хойших үйл явдал ба дараагийн аудитаар анхаарах асуудал**

Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 21,508.3 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 21,470.3 сая төгрөгийн алдааг залруулж, 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 33.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

##### **Залруулсан алдаа**

Дотоод албан томилолт болон УИХ-ын гишүүний тойрогт ажиллах зардал 6,840.8 сая, гэрээний төлбөр 14,629.5 сая, нийт 21,470.3 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг авлагаар бүртгэснийг залруулав.

##### **Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил**

Аудитаар 38.0 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 5.0 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Өмнөх аудитаар өгсөн ““Билгүүн засаг” ХХК-иас 2015 онд үүссэн 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “Эрх ба үүрэг” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх.

##### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 33.0 сая төгрөгийн алдаа, зөрчилд 5 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.



## 5. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Балансын данстай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд 16.9 сая төгрөгийн авлага, 0.9 сая төгрөгийн өглөг үүсгэсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэж заасныг зөрчсөн нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 1.2. Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 2. Балансын данстай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Бараа материалын дансанд 15.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэсэн байгаа нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 2.2. Эрсдэл: Үндсэн хөрөнгөд тавих дотоод хяналт сул байх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Хөрөнгийн бүртгэл хийхдээ УСНББОУС 12, 17-г мөрдөж, хөрөнгийг ангиллын дагуу зөв ангилан бүртгэж байх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 3. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа

- 3.1. Илрүүлэлт: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2016 онд боловсруулан мөрдөж эхэлснээс хойш холбогдох стандарт, хууль тогтоомж, заавар журмын өөрчлөлтийг тусгаагүй нь "Эрх ба үүрэг" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 3.2. Эрсдэл: Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа, холбогдох хууль, тогтоомж, стандарттай нийцэхгүй байх, санхүүгийн тайлан, мэдээ буруу илэрхийлэгдэх.
- 3.3. Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль, тогтоомж, стандартад нийцүүлэн шинэчлэх, данс бүртгэлийг холбогдох журмын дагуу үнэн зөв хөтлөх, зөрчлийг давтан гарахгүй байх.
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

### 4. Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлт

- 4.1. Илрүүлэлт: Улсын Их Хурлын гишүүдийн төсөвт зардлыг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаж хэвшээгүй, зардлын баримт нь анхан шатны баримтын /e-barimt/ шаардлагыг бүрэн хангаагүй нь "Үнэн зөв байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 4.2. Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахгүй байх.
- 4.3. Өгсөн зөвлөмж: Улсын Их Хурлын 2008 оны 28 дугаар тогтоолоор баталсан "Улсын Их Хурлын гишүүний төсөвт зардлыг төлөвлөх, тооцох, зарцуулах, тайлагнах журам"-ыг мөрдөж ажиллах.
- 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

## **5. Балансын данстай холбоотой асуудал**

- 5.1. Илрүүлэлт: Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11,938 нэгж үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээ хийлгэх болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг актлах талаар арга хэмжээ аваагүй нь “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.
- 5.2. Эрсдэл: Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллахгүй байх.
- 5.3. Өгсөн зөвлөмж: УСНББОУС 17 “Үндсэн хөрөнгө”-д дансны үнэ ба бодит үнэ цэнийн хооронд материаллаг зөрүү гаргахгүй байх үүднээс тайлагналын үеийн эцэс бүрт хөрөнгийн бодит үнэ цэнэ, ашиглалтын хугацааг тооцож үздэг байх. Шаардлагатай бол хөрөнгийг дахин үнэлэх гэж заасныг хэрэгжүүлж ажиллах.
- 5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Аудитаар гарсан алдаа, зөрчлийг хүлээн зөвшөөрч, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 09 дүгээр сарын 30 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Хавсралт

| №          | Алдаа, зөрчлийн товч утга   | Мөнгөн дүн /сая төгрөг/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны |                                |
|------------|---|-------------------------|---------------------------------------|---|--------------------------------|
|            |   |                         |                                       | Албан тушаал                                      | Овог нэр                       |
|            | 1   | 2                       | 3                                     | 4   | 5                              |
| 1          | Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэж заасныг зөрчин тайлант онд 16.9 сая төгрөгийн авлага, 0.9 сая төгрөгийн өглөг үүсгэсэн.  | 17.8                    | Зөвлөмж                               | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| 2          | Бараа материалын дансанд 15.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй.  | 15.2                    | Зөвлөмж                               | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| 3          | Үндэсний аудитын газраас 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн “Билгүүн засаг” ХХК-иас 2015 онд үүссэн 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах” гэж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй.                        | 5.0                     | Албан шаардлага                       | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| 4          | УИХ-ын гишүүдийн төсөвт зардлыг төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнаж хэвшээгүй, анхан шатны баримтын /e-bagimt/ шаардлагыг бүрэн хангаагүй.   | -                       | Зөвлөмж                               | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| 5          | Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 11,938 нэгж үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацааг шинэчлэн тогтоож, дахин үнэлгээ хийлгэх болон цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг актлах талаар арга хэмжээ аваагүй байна. | -                       | Зөвлөмж                               | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| 6          | НБББББ-ийг 2016 онд боловсруулан мөрдөж эхэлснээс хойш стандарт, хууль, тогтоомж, заавар журмын өөрчлөлт, шинэчлэлтийг тусгаагүй.   | -                       | Зөвлөмж                               | Дарга Ерөнхий нягтлан бодогч                      | Л.Өлзийсайхан<br>Б.Лхагвасүрэн |
| <b>ДҮН</b> |   | <b>38.0</b>             |                                       |   |                                |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 04 дугаар сарын 26

№ 540/А 016 0056

Улаанбаатар хот

С.АТ-2021/29/СТА-ТЭЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улсын Их Хурлын даргын 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитын зөвлөмжөөр “Билгүүн засаг ХХК-иас авах 2015 онд үүссэн 5.0 сая төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллах” гэсэн зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.3-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлсэн ажил, түүний үр дүнг төрийн аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд мэдэгдэнэ” гэсэн заалттай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн аудитын байгууллагаас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2021 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Өлзийсайхан, ерөнхий нягтлан бодогч Б.Лхагвасүрэн нарт хариуцуулав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

АУДИТЫН ДӨРӨВДҮГЭЭР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Я.САМБУУНЯМ

АХЛАХ АУДИТОР

А.ДАВААДОРЖ